



# ГОЛОМТ БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 00/05

Улаанбаатар хот

## Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.3 дахь хэсэг, Голомт банкны дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.9 дэх заалт, Голомт банкны 2024 оны 03 дүгээр сарын 05-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дугаар сарын 15-ны өдөр зарлаж, өглөөний 09 цагт, Шангри-Ла зочид буудлын хурлын их танхимд зохион байгуулсугай.
2. Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
  - 2.1 Голомт Банк ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулга.
  - 2.2 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт.
  - 2.3 2023 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн - Хөндлөнгийн аудитын дүгнэлт.
  - 2.4 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн Тогтоолыг танилцуулах.
  - 2.5 2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан. 2024 оны цалингийн төсөв.
  - 2.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
  - 2.7 Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх тухай.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.4-г заасан шаардлагыг ханган хурал заралсан тухай мэдээллийг олон нийтэд мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг дараах байдлаар тогтоосугай. Үүнд:
  - 5.1 Голомт банкны 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
  - 5.2 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт.
  - 5.3 2023 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн - Хөндлөнгийн аудитын дүгнэлт
  - 5.4 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн Тогтоолыг танилцуулах
  - 5.5 2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан. 2024 оны цалингийн төсөв.
  - 5.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулага.
  - 5.7 Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээлэл
6. Санал хураалтаар ирүүлсэн саналыг тоолох, үр дүнг гаргах Тооллогын комиссыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг энэхүү тогтоолын Хавсралт №2-ийн дагуу баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдээс санал авах саналын хуудасыг энэхүү тогтоолын Хавсралт №3-ийн дагуу баталсугай.
9. Саналын хуудсаар урьдчилан санал өгөх боломжийг хангаж, саналын хуудсыг урдчилан хүлээн авах хугацааг 2024 оны 04 сарын 03-ны өдрөөс эхлэн 04 сарын 10-ний өдрийн 12:00 цагаар тасалбар болгосугай.
10. Хурлын даргаар жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл Голомт банкны Ерөнхийлөгч Г.Ганболд-ыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.МӨНХЦЭЦЭГ